



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/683

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2018 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 317 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 218 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм”-ийн 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.НҮБ-ын Хүүхдийн сангийн Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөрийн хөрөнгөөр хийгдсэн ГАОНӨГ/202008127 дугаар гэрээт Есөнбулаг сумын гэр хороололд бохирын шугам татах ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.


Комиссын дарга:	Б.Бямбадорж	-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот, байгуулалтын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	М.Мөнхцэцэг	-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын инженерийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн
Гишүүдэд:	М.Мандахүү	-аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга
	М.Эрдэнэбилэг	-Усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөрийн орон нутгийн зөвлөх
	Ч.Жаргалсайхан	-Усан хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөрийн түр зөвлөх
	Б.Балдорж	-Орон нутгийн өмчийн газрын өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Д.Байгальмаа	-“Ундарга-Алтай” ААТҮГ-ын ашиглалтын инженер
	Б.Эрдэнэ-Очир	-“Ундарга-Алтай” ААТҮГ-ын дарга
	С.Баттөр	-“Мөнхтооройт” ХХК-ийн захирал

2.

2.Есөнбулаг сумын гэр хороололд бохирын шугам татах ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа техникийн нөхцөл, зураг төсөв, ажлын тоо хэмжээтэй нийцүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг танилцуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын сайтад байршуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан акт, баримт бичгийг үндэслэн хөрөнгийг бүртгэж, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгах, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг “Ундарга-Алтай” орон аж ахуй тооцоот үйлдвэрийн газар (Б.Эрдэнэ-Очир)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБАТ